



**"ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: "Тавантолгой" ХК Регистрийн дугаар: 2016656 Улсын бүртгэлийн дугаар: 1110001005 Үнэт цаасны код: TTL Албан ёсны хаяг: Монгол улс, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг, Тавантолгой ХК Вэб сайт: www.tavantolgoi.mn И-мэйл: info@tavantolgoi.mn Утас: 7535-5555, 9500-1619
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Уул уурхай, Нүүрс олборлолт
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	52,665,200 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Бөхбат, Төлөвлөлтийн эдийн засагч С.Энхбаяр Хянасан: Санхүү эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарантуяа
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1	Санхүүгийн байдлын үзүүлэлт	/мянган төгрөг/	
		2024.12.31	2025.06.30
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	373,701,070.9	156,246,900.5
	Дансны ба бусад авлага	53,227,154.8	72,586,053.2
	Бараа материал	219,319,588.1	174,715,774.3
	Урьдчилж төлсөн зардал тооцоо	68,825,671.9	73,259,038.3
	Бусад эргэлтийн хөрөнгө	17,967.1	28,238.1
		715,091,452.8	476,836,004.5
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	26,578,000.0	24,969,915.0
	Биет бус хөрөнгө	6,593,329.4	6,810,491.6
	Биологийн хөрөнгө	43,707.1	31,417.1
	Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179.5	434,179.5
	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,325,464.6	3,139,974.5
	Бусад эргэлтийн бус хөрөнгө	31,358,326.9	34,126,573.6
		68,333,007.5	69,512,551.1
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	783,424,460.3	546,348,555.5
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	19,250,987.7	20,802,373.1
	Татварын өр	22,573,244.4	23,915,621.1
	Ногдол ашгийн өглөг	658,515.4	187,599,243.4
	Урьдчилж орсон орлого	202,309,176.9	77,747,756.5
	Бусад богино хугацаат өр төлбөр	16,636,153.4	22,760,195.8
		261,428,077.8	332,825,189.9
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат зээл	-	-
	Нөөц / өр төлбөр/	8,218,026.8	8,218,026.8
	Хойшлогдсон татварын өр	4,451,524.3	4,451,524.3
	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
		12,669,551.1	12,669,551.1
	Өр төлбөрийн нийт дүн	274,097,628.9	345,494,741.0
	Эздийн өмч		
	Төрийн өмч	48,188.7	48,188.7
	Хувийн өмч	46,298.9	46,298.9
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,876,231.6	5,876,231.6
	Хуримтлагдсан ашиг	503,356,112.2	194,883,095.3
		509,326,831.4	200,853,814.6
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	783,424,460.3	546,348,555.5

1.2	ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	/мянган төгрөг/	
		2024.12.31	2025.06.30
	Үзүүлэлт		
	Борлуулалтын орлого	1,158,398,002.6	198,085,515.1
	Борлуулалтын өртөг	589,030,425.7	114,230,463.6
	Нийт ашиг	569,367,576.9	83,855,051.5
	Бусад орлого	6,765,311.3	1,588,315.9
	Борлуулалт, маркетингийн зардал	4,368,300.6	2,827,840.0
	Ерөнхий ба удирдлагын зардал	16,575,572.5	10,903,799.4
	Бусад зардал	2,711,170.1	206,135.9
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-3,318,264.0	11,237,329.2
	Татвар төлөхийн өмнөх ашиг	549,159,581.0	82,742,921.2
	Орлогын татварын зардал	136,804,310.7	18,585,730.3
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	412,355,270.3	64,157,190.9
1.3	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	/мянган төгрөг/	
		2024.12.31	2025.06.30
	Үзүүлэлт		
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,611,904.8)	(59,825,524.2)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,606,671.9)	1,560,798.3
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(290,508,967.3)	(159,189,444.4)
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(7,904,253.1)	(5,922,171.7)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(344,727,544.1)	(217,454,170.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	718,428,614.9	373,701,070.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	373,701,070.9	156,246,900.5

1.4	ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН				/мянган төгрөг/
	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл					
		94,487.6	5,876,231.6	721,340,561.5	727,311,280.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	(10,086,696.9)	(10,086,696.9)
Залруулсан үлдэгдэл		94,487.6	5,876,231.6	711,253,864.6	717,224,583.8
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт		-	-	-	-
Зарласан ногдол ашиг		-	-	(297,488,351.9)	(297,488,351.9)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-	-	412,355,270.3	412,355,270.3
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл					
		94,487.6	5,876,231.6	503,356,112.2	509,326,831.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	(180,689.3)	(180,689.3)
Залруулсан үлдэгдэл		94,487.6	5,876,231.6	503,175,422.9	509,146,142.1
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт		-	-	-	-
Зарласан ногдол ашиг		-	-	(366,639,435.6)	(366,639,435.6)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-	-	64,157,190.9	64,157,190.9
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-	-	-	-
2025 оны 6-р сарын 30-ээрх үлдэгдэл					
		94,487.6	5,876,231.6	194,883,095.3	200,853,814.6
2	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт.				

ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ
ДҮГНЭЛТ

2025 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2025 оны хагас жилийн үйл ажиллагаа,
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Тавантолгой хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо хуралдаж Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.1 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.1.4 дэх заалт, Компанийн дүрмийн наймын 8.3.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийн хүрээнд компанийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай танилцаад доорх дүгнэлтийг гаргаж байна.

Тавантолгой хувьцаат компанийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан нь холбогдох хууль, дүрэм журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болохыг зөвшөөрч байгаа тул олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрч байна.

Иймд компанийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын Хөрөнгийн бирж" ХХК зэрэг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА



Ч.ОТГОНБАЯР

3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь: 32.4% Эздийн өмчийн өгөөж /ROE/: 18.1% Нийт хөрөнгийн өгөөж /ROA/: 9.6%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 1.43 Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа: 0.91
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	- Компанийн үндсэн үйлдвэрлэлийн тоо хэмжээг Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн хүрээнд нэмэгдүүлэн ажиллах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. - 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж буй "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай" хуулийн хүрээнд экспортолж буй бүтээгдэхүүнийг 100% Монголын хөрөнгийн биржээр дуудлага худалдаагаар арилжиж ажилласан. - Тайлант хугацаанд 500.7 мянган тонн нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 дахин, борлуулалтын орлогын хувьд 2.6 дахин буурсан үзүүлэлттэй байна. - Борлуулалтын үзүүлэлтүүд буурсан гол шалтгаан нь нүүрсний үнийн уналт, макро эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалсан худалдан авагчдын эрэлт буурсантай холбоотой байна. - Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан ТУЗ-ын шийдвэрээр компани 2025 оны 2-р сарын 10-ний өдрөөс хэмнэлтийн горимд шилжиж, нийт ажилтнуудын 80%-ийг сул зогсолтод хамруулсан. Хэмнэлтийн горим үргэлжилж байгаа бөгөөд зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан борлуулалтын үйл ажиллагаа сэргэж байгаатай холбоотой сул зогсолтод хамрагдсан ажилтнуудыг үе шаттайгаар хэвийн ажиллуулж эхлэж байна. Улмаар энэ ондоо багтаан бүх ажилтнуудад хэвийн горимоор ажиллуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. - 2025 оны 6 дугаар сарын сүүлийн хагасаас нүүрсний үнэ сэргэж худалдан авагчдын эрэлт нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нүүрсний экспортыг биет хэмжээгээр өнгөрсөн оноос бууруулахгүй байхаар төлөвлөн ажиллаж байна.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	"Тавантолгой" ХК нь 2025 оны эхний хагас жилд Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НББББичгийн дагуу бүртгэсэн.

4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
	Тайлант хугацаанд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргаагүй.
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ “Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Компанийн оффис (Монгол Улс, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо 3 дугаар баг, Компанийн оффисын 2 давхар)-т амжилттай зохион байгуулагдав. Хурлын ирц Хуралд нийт 52,665,200 ширхэг хувьцааны 49,884,021 ширхэг хувьцаа буюу 20 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц, хувьцаа хувь 94,72% болж хурал хүчин төгөлдөр явагдав. Хурлаар танилцуулсан асуудал 1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай 2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай 3. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай 4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах 5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай 6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай 7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай Хурлаас гарсан шийдвэр Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав. 1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй, гэсэн тогтоолыг гаргав. 2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн дүгнэлтийг хэлэлцээд дүгнэлтийг батлав.

3. "Тавантолгой" ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайлантай танилцаад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй, гэсэн тогтоолыг батлав.
4. "Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэртэй танилцаад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй, гэсэн тогтоолыг батлав.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлантай танилцаад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй, гэсэн тогтоолыг батлав.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй сонгон томилов.
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг баталсан тогтоол гаргав.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан. 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ХЭХ-ийн материал (Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хэвлэмэл материал, Хурлын тайлан хэвлэмэл материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан. СЗХ, МХБ-ээс тайлан хүлээн авч танилцсан тухай албан тоотыг компанид ирүүлсэн болно.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор компанийн гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт өгснийг хэлэлцээд гүйцэтгэх захирал Ч.Гүнждагвыг үүрэгт ажлаас чөлөөлөв. 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Адьяацэрэн өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хэлэлцээд үүрэгт ажлаас нь чөлөөлж, 44 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг Ажил түр хавсран гүйцэтгүүлэх тухай тогтоол гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Э.Бөхбатыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг түр хавсран гүйцэтгэгчээр томилов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаярыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар улируулан томилов. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаярын өөрийнх нь хүсэлтийг үндэслэн ТУЗ-ийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж, 47 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Мэндбаярыг сонгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар тогтоолоор компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ш.Отгонбаярыг томилов.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ			
Хурал	Ээлжит хурал	Хэлэлцсэн асуудал	Баталсан тогтоол
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал	21	52	61
Төлөөлөн Удирдах зөвлөл нь 2025 оны хагас жилд танхим болон цахим хосолсон байдлаар 21 удаа хуралдаж 52 асуудлыг хэлэлцэж 61 тогтоолыг баталсан. НОГДОЛ АШИГ “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу компанийн 2024 оны татвар төлсний дараа цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 6960 төгрөг хуваарилахаар шийдвэрлэн ногдол ашиг хуваарилсан. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ Эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан. - 2024 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (Монгол, Англи хэлээр); - 2024 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (Монгол, Англи хэлээр); - 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал; - Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2025 оны хагас жилийн байдлаар тайланг ТУЗ-ийн албан тоотоор хүргүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны албан тоот 2025-07-09, №19, “Монголын Хөрөнгийн бирж” ХК албан тоот 2025-07-09, №20); - Тухай бүр хүргэх мэдээллүүд. ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД Компанийн бүтэц орон тоо, газрын чиг үүрэг, албан тушаалын зэрэглэл, шатлалыг баталсан. (ТУЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол)			
Мэдээлэл гаргач этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:			
Овог, нэр:	Ш.Отгонбаяр		
Албан тушаал:	“Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч		
Гарын үсэг:			
(Тамга/тэмдэг)			
			
Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:			
Овог, нэр:	Э.Бөхбат		
Албан тушаал:	“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга		
Гарын үсэг:			
			